



**НИЙСЛЭЛИЙН ХАНГАРДИ ОДОНТ
НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ-ЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1.Байгууллагын үүсэл

Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны 1974 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 08 тоот тогтоолоор Хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны шууд харьяа газар, хэлтсүүдийн жижүүр, дуудлага үйлчилгээний авто машиныг нэгтгэн Сангийн Яамнаас баталсан төсвийн дагуу хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны харьяанд хөнгөн тэрэгний авто паркийн зориулалтаар анх байгуулагдаж 1992 онд АДХГЗ-ны 23 дугаар тогтоолоор 46 автомашин хөдлөх бүрэлдэхүүнтэйгээр Улаанбаатар хотын АДХГЗ-ны Авто бааз нэртэй, 1994 оноос Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авто бааз, 2007 оны 07 дугаар сараас Нийслэлийн төр захиргааны авто бааз нэртэйгээр нийслэлийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар болон өргөжиж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн ажлын алба, нийслэлийн харьяа байгууллагуудад автомашинаар үйлчлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

1.2.Байгууллагын бүтэц, орон тоо

Байгууллагын бүтэц, орон тоо нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагддаг бөгөөд хамгийн сүүлд 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын А/995 дугаар захирамжаар тус байгууллагын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэдэж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/614 захирамжаар байгууллагын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан. Үүнд:

Хэлтэс		Орон тоо
1	Дарга	1
Захиргаа, хүний нөөцийн хэлтэс		9
1	Хэлтсийн дарга	1
2	Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	1
3	Хүний нөөцийн ажилтан	1
4	Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан	1
5	Үйлчилгээний ажилтан	1
6	Манаач	1
Санхүү, төлөвлөлтийн хэлтэс		3
1	Хэлтсийн дарга	1
2	Эдийн засагч, нягтлан бодогч	1
3	Техникч-нярав	1
Тээвэр, зохицуулалтын хэлтэс		92
1	Хэлтсийн дарга	1
2	Ашиглалтын инженер	1
3	Механик инженер	1
4	Диспетчер-механик	8
5	Үйлчилгээний жолооч	78
6	Механик засварчин	2
7	Сантехникч	1
Хэлтэс 3, нийт албан хаагчийн тоо 105.		Нийт 105

1.3.Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995 дугаар захирамжаар Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь дараах чиг үүргийг гүйцэтгэхээр дүрэмд заасан. Үүнд:

1.	Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулан, байгууллагуудад автомашинаар үйлчлэх.
2.	Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн болон Төрийн үйлчилгээний соёлд тавигдах шаардлага, стандарт, норм, нормативыг мөрдөх, соёлч боловсон, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх.
3.	Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан балансыг зохих хугацаанд гаргах.
4.	Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, жолооч нарын боловсрол, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах.
5.	Авто үйлчилгээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах, жолооч нарын ангилал дээшлүүлэх, сургах мэргэшүүлэх, хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах
6.	Шатахуун, тослох материал, автомашины сэлбэг, дулаан, цахилгаан, усны үнэ нэмэгдэхэд үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бусад холбогдох газруудтай хамтран боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулан, шийдвэрлүүлж, мөрдөж ажиллах

ХОЁР. АВТО ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Дуудлага үйлчилгээний зохицуулалт


Тээвэр зохицуулалтын хэлтэс нь Хэлтсийн дарга, ерөнхий инженер 1, Ашиглалтын инженер 1, ХАБ инженер 1, Диспетчер механик 8, Механик засварчин 2, Үйлчилгээний жолооч 78, Сантехникч 1 нийт, 92 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үйлчилгээний жолооч, диспетчер механик нарыг бригадын зохион байгуулалтад оруулан ажиллаж байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар кузов засвар, ТҮ-1, ТҮ-2 техник үйлчилгээг автомашинд графикийн дагуу хийж, техникийн үзлэг оношилгоонд 86 тээврийн хэрэгслийг бүрэн хамруулсан. Давхардсан тоогоор 144 тээврийн хэрэгсэлд засвар хийсэн бөгөөд 37 тээврийн хэрэгслийн тос масло, маслоны шүүр, салоны агаар шүүгч, заалны агаар шүүгч сольж 3 тээврийн хэрэгслийг кузов засварт оруулсан.




Байгууллагын нийт хөдлөх бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/15 захирамжийн 1.4.3 дахь заалтын дагуу техникийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд 86 тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд 100% бүрэн хамруулсан.

Мөн 2025 оны эхний хагас жилд парк шинэчлэлтээр 9 тээврийн хэрэгслийг техникийн комисс хүлээн авсан.



Долоо хоног бүр Smart.mn аппликейшнаар үйлчилгээний жолооч нарын замын хөдөлгөөний зөрчлийн торгуулийг шүүн төлбөрийг барагдуулахад хяналт тавьж, 2025 оны хагас жилийн байдлаар нийт 415,000 төгрөгийн торгуулийг зөрчил гаргасан үйлчилгээний жолооч нараар төлүүлж барагдуулсан.



Үйлчилгээний соёл, чанар, стандартыг ханган ажиллах, диспетчер механикийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хагас жилийн хугацаанд хуваарийн дагуу ажлын байрны шалгалтыг нийт 20 удаа хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг дор бүр арилгуулж, цаашид анхаарч ажиллах, үйлчилгээний жолооч нарын хувцаслалт, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмж дээр анхаарч ажиллах чиглэл өгсөн.



2.2. Байгууллагын тээврийн хэрэгслийн насжилт, парк ашиглалтын үзүүлэлт


Тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн оноор нь жагсаан насжилтын судалгааг гаргасан бөгөөд график үзүүлэлтээр харьцууллаа. Үүнд:



➤ Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг ангилал




2025 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 539,458 км замыг туулж парк ашиглалтын дундаж үзүүлэлт 87,3% болж өссөн үзүүлэлттэй.



2.3. Дуудлага, үйлчилгээ


Дуудлагын автомашин захиалгын систем 2025.01.01-ний өдрөөс 2025.06.15-ны өдрийг хүртэл нийтдээ 456 захиалга авсан үүнээс системээр 307 захиалга, утсаар 149 захиалга авч 421 захиалгыг хүлээн авч ажил үйлчилгээнд гаргасан байна. Захиалагч байгууллагуудын санаачилгаар 35 захиалга цуцлагдсан байна.

01 дүгээр сар




■ Нийт ■ ERP системээр ■ Утсаар

02 дугаар сар




■ Нийт ■ ERP ■ Утсаар

03 дугаар сар




■ Нийт ■ ERP ■ Утсаар ■

04 дүгээр сар




■ Нийт ■ ERP ■ Утсаар

05 дугаар сар



■ Нийт ■ ERP ■ Утсаар

06 дугаар сар



■ Нийт ■ ERP ■ Утсаар



2025 оны хагас жилийн байдлаар “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтэд оролцсон гадаад, дотоодын тамирчид, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн бизнес инновацийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний газар, Чингэлтэй дүүргийн Иргэдийн хурал, Сүхбаатар дүүргийн Иргэдийн хурал, төсөл нэгжүүдийн зочны үйлчилгээнд тээврийн хэрэгслийн үйлчилгээг үзүүлэн ажилласан.

ГУРАВ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Санхүүгийн тайлан, орлого, зарлага

Санхүү төлөвлөлтийн хэлтэс нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад эдийн засаг, санхүүгийн чиг үүргийг хэрэгжүүлэн, төсөв, санхүүг хугацаанд нь үр ашигтай зөв зарцуулан, “Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” болон бусад холбогдох дээд газруудаас гарсан шийдвэр хууль, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон удирдлагыг бодит мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.

2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг тайлант хугацаанд тайлагнан Сангийн яам, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газар, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс, Нийгмийн Даатгалын хэлтэс, Нийслэл дэх Төрийн аудитын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газарт тус тус цаасан болон цахим хэлбэрээр тайланг бэлтгэн гаргаж баталгаажуулан ажилласан.

3.1.1. Тайлан

2025 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст сар бүр 5-ний өдрийн дотор, дуудлагын автомашины үйлчилгээ үзүүлсэн төлбөрийн баримтыг татварын албаны Ebarmt цахим системд сар бүрийн 21-25-ны өдрийн дотор, шилэн дансны тайланг сар бүрийн 7-ны өдрийн дотор, нийгмийн даатгалын тайланг 5-ны өдрийн дотор, цалин хөлсний тайланг 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тус тус мэдээлэн тайлагнан ажилласан. 2024 оны санхүүгийн тайланг дараах байдлаар холбогдох газруудад 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор тайлагнан ажилласан. Үүнд:

Сангийн яамны и-баланс

- Э-ТАЙЛАН

Байгууллага: ҮБ, Нэгдсэн эмнэлэг

Таблиц №: 2022-01

Урсгал	ЭБ	ЭМ	ЭН	ЭО	ЭС	Байршил	Байршил нэр	Байршилны нэр	Байршилны нэр
1-1-1	✓	✓	✓	✓	✓	✓	2022.02.15	Хүндэтгэл үйлд	2022.02.15
2-1-1	✓	✓	✓	✓	✓	✓	2022.02.15	Хүндэтгэл үйлд	2022.02.15
3-1-1	✓	✓	✓	✓	✓	✓	2022.02.15	Хүндэтгэл үйлд	2022.02.15
4-1-1	✓	✓	✓	✓	✓	✓	2022.02.15	Хүндэтгэл үйлд	2022.02.15


✓ - Өгөгдөл бүрэн
 ✗ - Хүндэтгэл үйлд
 ✗ - Хүндэтгэл үйлд
 ✗ - Хүндэтгэл үйлд

© 2022 Э-ТАЙЛАН. Бүх эрх хуульчилж авч үзэх.

-
- The screenshot displays the official website of the Mongolian State Audit. On the left is the homepage layout, featuring the Mongolian State Audit logo and the text "ТӨРИЙН АУДИТ" (State Audit). The main content area includes a search bar, a list of links, and a "Бүтээгдэхүүн" (Products) section. On the right is a detailed flowchart titled "ТӨРИЙН АУДИТЫН ТҮЛГҮҮР ЗҮРЧЛҮҮД" (Main Objectives of State Audit). The flowchart consists of eight colored boxes arranged in two rows, each containing an icon, a title, and a brief description. The boxes are color-coded: orange, blue, green, and yellow. The flowchart illustrates the various types of audits conducted by the Mongolian State Audit, including financial audits, performance audits, and compliance audits.


[illegible]

-Татварын албаны цахим татварын систем



Албан бичгийн мэдээ

2025 онд нийт эхний хагас жилийн байдлаар нийт 31 албан бичиг ирсэн. Үүнээс 21 бичиг хариугүй, 10 бичиг буцах хариутай байсан ба хугацаанд нь хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн болно. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад нийт 51 бичиг явуулсны, 30 нь хариугүй, 8 бичиг хариутай бичиг хүргүүлэн ажилласан байна. 2024 оны хагас жилтэй харьцуулахад шийдвэрлэсэн бичгийн явц ирсэн бичиг 8.5 буурч, илгээсэн бичиг 2 дахин нэмэгдсэн байна.



3.1.2. Үйл ажиллагааны орлогын тухай

Үйл ажиллагааны орлого төсвийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг. 2025 оноос 100% төсөвт байгууллагын статуст шилжин нийт 1,302.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлэн ажиллахаар


төсөвлөгдсөн. 2025 оны эхний хагас хагас жилийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна.

2025 оны орлогын төлөвлөгөөний харьцуулалт (сая.төг)

Д/д	Орлого	2025 оны төлөвлөгөө	2024 оны хагас жилийн төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөөний биелэлтийн (хувь)
1.	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,302.8	771.7	59.2%
2.	Төсвийн санхүүжилт	3,238.4	1,882.8	58.1%

Үндсэн үйл ажиллагааны орлого 771.7 сая төгрөг, төсвийн санхүүжилт 1,181.3 сая төгрөг, өөрийн орлогын төлөвлөгөө 37.2% гүйцэтгэлтэй ажиллаж байна. Нийт орлого 1,710.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Үйл ажиллагааны орлогыг 2024 оны хагас жилтэй харьцуулан үзэхэд:



Төсвийн санхүүжилт 59.3% болж өссөн нь Цалин хөлсний шатлалын доод хэмжээ шинэчлэгдэн нэмэгдсэнтэй холбоотой, үйл ажиллагааны орлого 45.9%-иар өссөн нь Нийслэлийн дүүрэг, агентлагуудын дуудлагын автомашины захиалгын үйлчилгээ нэмэгдэж парк ашиглалтын хэмжээ өссөнтэй холбоотой байна.

3.1.3.Үйл ажиллагааны зарлагын тухай

2025 оноос байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийн зохицуулалт 100% төсөвт харьяалагдаж өөрийн орлого болон төсвөөс санхүүжин, Төрийн сан дахь бүртгэлийн дансаар батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалтыг хийн ажиллаж байна.

➤ Үндсэн үйл ажиллагааны зардал


Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл /хагас жил/	Гүйц (төл) хэмнэлт, хэтрэлт (+/-)	
			сая.төг	Хувь
Нийт зардлын дүн	4,541.2	2,717.4	1,823.8	59.9%
Цалин хөлс шагнал	2,913.3	1,772.8	1,140.5	60.9%
Нийгмийн даатгалын шимтгэл	364.1	307.9	56.2	84.4%
Байр ашиглалттай холбоотой зардал	400.9	202.3	198.6	50.4%
Хангамж бараа материалын зардал	47.6	17.9	29.7	37.6%
Эд хогшлийн урсгал засварын зардал	168.3	98.0	70.3	58.3%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	51.7	19.2	32.5	37.1%
Шатахууны зардал	456.1	237.0	219.1	51.9%
Бусад зардал	139.2	62.3	76.9	44.7%

Батлагдсан орон тоо, төсвийн дагуу төсвийн санхүүжилтийг сар бүр авч дотоод журамд заасны дагуу 10, 25-ны өдрүүдэд ажилтан албан хаагчдын цалин хөлсийг тооцон олгож, үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт төсвийн 59.8%-ийн гүйцэтгэлтэй, бусад зардалд тусгагдсан өндөр насны тэтгэвэрт суух албан хаагчдын 50% буюу 2 ажилтанд 47.5 сая төгрөгийн тэтгэмж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээн 10.2 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгон ажиллаж байна.

3.2.Ил тод байдал

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийн 1 дэх заалтад “Нийслэлийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын 2015 оны Санхүүгийн жилийн анхны дансны гүйлгээ хийгдэх хугацаанаас эхлэн шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, ажиллахыг Нийслэл, дүүргийн бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай” гэж заасны дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, стандарт, журмын дагуу холбогдох мэдээллийг байршуулж ажиллаж байна. 2025 онд нийт 171 мэдээлэл байршуулахаас 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 66 мэдээллийг байршуулан 38.6% биелэлттэй ажиллаж байна.



2024 оны 12 дугаар сараас эхлүүлэн байгууллагын тээврийн хэрэгслүүдийн парк шинэчлэлтийн ажлыг газрын даргын хамт Нийслэлийн Засаг даргын тамгын газарт уламжлан танилцуулж 2025 оны 1-р улиралд шийдвэр болох Нийслэлийн Засаг даргын А/228 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын тамгын газрын төсөвт тус ажлын төсвийг суулгуулж, холбогдох ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт хүргүүлэн ажилласан. Тус ажлын хүрээнд Голомт банкны санхүүгийн түрээсийн үйлчилгээгээр авто баазын парк шинэчлэлтийн ажлыг хийхээр болсон. 2025 оны 2-р улиралд нийт парк шинэчлэлтийн ажлын 19.1% гүйцэтгэлтэй, хүлээгдэж буй гүйцэтгэл 80.1%-тай ажиллаж байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа аж ахуйн тооцоотоос төсөвт шилжин үйл ажиллагаа зарчим өөрчлөгдсөнтэй холбоотой санхүүгийн программыг шинэчлэх шаардлагатай болсон. Төсөв байгууллагын үйл ажиллагаанд нийцсэн “Санхүүгийн тооцоолох групп ХХК”-ийн акколус-4.0 программыг амжилттай нэвтрүүлэн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулах, төсвийн зардлыг хэмнэх, орлогын төлөвлөгөөг биелүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг хэтрүүлэхгүй норм нормативыг баримтлан, өмчийн ашиглалтыг сайжруулж ажиллаж байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Олон нийтийн үйл ажиллагаа

“Тэрбум мод” Үндэсний хөпөдгөөний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр буюу “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ийг тохиолдуулан “Нийслэлийн Төр захиргааны авто бааз” УТҮГ-ын хамт олон Хан-Уул дүүргийн Айцын аманд тарьсан модоо усалж, арчиллаа.



4.2. Байгууллагын дэргэдэх зөвлөл, комисс, бригадын үйл ажиллагаа

Байгууллагын зүгээс “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан нийт ажилтан, албан хаагчдын 168 хүүхдэд бэлэг гардуулсан.

4.3. Хурал зөвлөгөөн, сургалт семинар

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Чадавхжуулах” сургалтуудад дараах албан хаагчид хамрагдсан. Үүнд:

- 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр “Стрессын менежмент” сэдэвт сургалтад ХАБ-ын инженер Ц.Энхжаргал,
- 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр “Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмж нэмэгдүүлэх” сэдэвт сургалтад эдийн засагч, нягтлан бодогч Т.Бадамдагий,
- 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр “Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмж нэмэгдүүлэх” сэдэвт сургалтад нь ашиглалтын инженер Ц.Оюунцэцэг,
- 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт сургалтад мэдээллийн технологи, архив бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа,
- 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр “BPR-Бизнес Процессийн загварчлал” сэдэвт сургалтад Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаа, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Үүрцайх,
- 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдөр “Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй” сэдэвт сургалтад ХАБ-ын инженер Ц.Энхжаргал,
- 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр “Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй” сэдэвт сургалтад ашиглалтын инженер Ц.Оюунцэцэг,

- 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр “Төслийн удирдлагын үндэс” сэдэвт сургалтад Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Үүрцайх,
- 2025 оны 03 дугаар сарын “Архив албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журам” сэдэвт сургалтад мэдээллийн технологи, архив бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа,
- 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр “Төслийн удирдлагын үндэс” сэдэвт сургалтад Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаа нар тус тус хамрагдсан.

Мөн үйлчилгээний жолооч Х.Арилдий №0008469, Б.Ариунболд №0013432, Б.Галаа №0018620, Э.Энх-Амар №0008435, Б.Сүхбаатар №64656 нар Мэргэшсэн зэргийн үнэмлэхийн хугацааг сунгуулсан. Мөн Үйлчилгээний жолооч Т.Нэргүй, Д.Одбаяр, О.Сүх-Эрдэнэ нар “В” ангиллын мэргэшсэн зэргийн сургалтад хамрагдсан байна. Байгууллагын нийт жолооч нарын 56 жолооч мэргэшсэн буюу 76% нь мэргэшсэн байна.

4.4. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх.

Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй Эрүүл мэндийн багц шинжилгээ хийлгэх гэрээ хийж, байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн багц шинжилгээнд 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрийн хугацаанд бүрэн хамруулсан.

- Газрын даргын 2025 оны Б/22 дугаар тушаалаар үйлчилгээний жолооч Ч.Гантөмөрт 1.500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/23 дугаар тушаалаар манаач Н.Нямаад 1.500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/26 дугаар тушаалаар диспетчер-механик Ч.Нарантуяад 1.000.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/39 дүгээр тушаалаар үйлчилгээний жолооч А.Баттулгад 500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/45 дугаар үйлчилгээний жолооч С.Баатарсүхэд 1.000.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/54 дүгээр тушаалаар ашиглалтын инженер Ц.Оюунцэцэгт 500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/38 дугаар тушаалаар ерөнхий инженер Ч.Энхсайханд 500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/55 дугаар тушаалаар захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаад 1.500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/65 дугаар тушаалаар ахмад настан Б.Намсрайд 500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/76 дугаар тушаалаар үйлчилгээний жолооч Б.Ариунболдод 500.000 төгрөг,
- Газрын даргын 2025 оны Б/79 дүгээр тушаалаар манаач Ж.Санжаад 500.000 төгрөгийг тус бүр 11 албан хаагчид нийт 10,000,000 төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгосон. Мөн ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг оношилгооны урьдчилгаа төлбөрт 1.500.000 төгрөг нийт, 11.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4.5.Нийгмийн хариуцлагын хүрээний ажил

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын албан хаагчид Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хорооны айл, өрх, аж ахуйн нэгж байгууллагын галлагааны аюулгүй байдалд шалгалт хийж, зөвлөгөө, зөвлөмж өгөн ажиллалаа.



2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Бүх нийтийн их цэвэрлэгээний хүрээнд байгууллагын гадна талбай, авто машины зогсоол, нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэлээ.



Нийслэлийн Засаг даргын 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” А/354 дүгээр захирамж, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 01/320 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” УТҮГ-ын албан хаагчид их цэвэрлэгээний

ажлын удирдамжид заасан хуваарийн дагуу нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэж, идэвхтэй оролцсон



4.6 Өргөдөл, гомдлын талаар

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын “Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг тухай бүрт www.erp.ulaanbaatar.mn программд, хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллалаа.

2025 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 26 өргөдөл хүсэлт ирснийг программд бүртгэн, 23 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 3 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. 11-11 төвөөс ирсэн 1 өргөдөл ирснийг холбогдох албан хаагчдад шилжүүлэн судалж байна. Үүнд:

1. Хүсэлт-26
 - ✓ Байгууллагын албан хаагчид-15
 - ✓ Иргэд-11

2. Гомдол-1
 - ✓ Байгууллагын албан хаагчид-0
 - ✓ Иргэд-1 ирсэн байна.

Хүснэгт-1 Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл, гомдол
	3	10	39	24

2025 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг өмнөх онтой харьцуулсан байдал

2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд манай байгууллагад ирсэн нийт 27 өргөдөл, гомдлыг “Өргөдөл,

гомдлын нэгдсэн программ”-д бүртгэсэн байна.

Өнгөрөгч 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 30 өргөдөл, гомдол хүлээн авч хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн байна. 2024-2025 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 2 дугаар улирлын дараах графикаар харьцуулсан. (График-1)

График-1



2025 оны 2 дугаар улирлын байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг (диаграмм-2) Захиргаа хүний нөөцийн хэлтэс 23, Санхүү, төлөвлөлтийн хэлтэс 4, байгууллагын хэмжээнд нийт 27 өргөдөл гомдлоос журмын дагуу хуулийн үндэслэлтэй 23 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна.

(Диаграмм 2)



(2025 оны 2 дугаар улирлын байдлаар)

2025 оны 2 дугаар улирлын байдлаар хандалтаараа тэргүүлж байгаа 3 асуудал нь ажилд орох хүсэлт 10 (37,04%), ажлаас чөлөөлөгдөх тухай 7 (25,93%) цалин, хөлсний тухай 4 (14,81%), ирсэн байна.

Өргөдөл, гомдлын программд нийт 27 өргөдлийг бүртгэж, 23 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 19 (82,61%), 10 хоногт 3 (13,04%), 30 хоногт 1 (4,35%).

2025 оны 2 дугаар улирлын байдлаар хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0,87 буюу "B" үнэлгээтэй байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:



Байгууллагын хэмжээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг өргөдөл, гомдлын асуудал хариуцсан ажилтан өдөрт нь хүлээн авч, өргөдөл гомдлын нэгдсэн системд бүртгэж, удирдлагад өдөрт багтаан шилжүүлж, удирдлагын цохолттой ирсэн өргөдөл, гомдлыг тухайн албан хаагч өдөр нь хүлээн авч танилцан, явцын тэмдэглэлийг 10 хоног тутам хийж ажилласан. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар өдөрт нь багтаан аваагүй зөрчил 23, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил 1, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Өргөдөл гомдлын зөрчлийг өмнөх онтой харьцуулахад 24 нэгжээр өссөн дүнтэй байна.

4.7.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу байгууллагад хандаж ирсэн 144, явсан нийт 116 бичиг байна.

Байгууллагын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийтээр дагаж мөрдөх, цаг үеийн шинж чанартай болон байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой захирамжлалын баримт бичгүүд Засгийн газрын 1 тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж 7, Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, албан даалгавар, зөвлөмж нийт 2 тус тус холбогдох заалтыг хэрэгжүүлэн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж, хяналт тавин ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ-ЫН БАРИМТ БИЧГИЙН ЭРГЭЛТИЙН ЖАГСААЛТ

2025 оны 06 дугаар сарын 26

Улаанбаатар хот

№	Баримт бичгийн нэр	2024 оны хагас жил	2025 оны хагас жил
1	Тогтоол	2	1
2	Захирамж	6	7

3	Албан даалгавар, тушаал, зөвлөмж	2	2
4	Даргын А тушаал	23	20
5	Даргын Б тушаал	64	85
6	Ирсэн бичиг: нийт	119	144
	Хариутай бичиг	38	30
	Хариугүй бичиг	81	114
7	Төлөвлөгөө	6	6
8	Тайлан, биелэлт	6	6
9	Өргөдөл, гомдол	46	27
10	Явуулсан бичиг:	107	116
11	Хурлын тэмдэглэл нийт:	37	37
	Захиргааны албан хаагчдын	21	21
	Даргын зөвлөлийн	4	4
	Ур чадварын нэмэгдэл	5	6
	Шуурхай хурал	0	0
	Шагналын	2	2
	Өмч хамгаалах	5	1
12	Гэрээ:	230	126
	Автомашинаар үйлчлэх гэрээ	48	19
	Үр дүнгийн гэрээ	1	1
	Хөдөлмөрийн гэрээ	101	19
	Эд хөрөнгийн гэрээ хариуцлагын	30	87
13	Дүгнэлт	43	14

Албан хэрэг хөтлөлтийн eDoc.ub.gov.mn

2025 оны эхний хагас жилийн байдлаар Захиргаа хүний нөөцийн хэлтэст-72, Санхүү төлөвлөлтийн хэлтэст-29, Тээвэр зохицуулалтын хэлтэст-43 албан бичиг ирж, нийт 144 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин 98,1%-ийн шийдвэрлэлттэй ажиллаж байна.



(2025 оны эхний хагас жилийн байдлаар)




(2025 оны эхний хагас жилийн байдлаар)

Явуулсан бичгийн шийдвэрлэлт нийт 116 үүнээс

- захиргаа хүний нөөцийн хэлтсийн 46. Хариутай 16 хариугүй 100 бичиг
- санхүү төлөвлөлтийн хэлтсээс нийт 48. Хариутай 8, хариугүй 40 бичиг
- тээвэр зохицуулалтын хэлтсээс нийт 22. Хариутай 3, хариугүй 19 бичиг

Байгууллагын хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлт


(2025.01.01-2025.06.26)



Байгууллагын хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлт 2025 оны 01 дүгээр сарын 01-с 06 дугаар сарын 26-ныг хүртэл нийт 144 албан бичгээс хариутай албан бичиг 30, хариугүй албан бичиг 114 ирсэн байна.

Үүнээс: хугацаандаа шийдвэрлэсэн 105, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4, судалж байгаа 5 албан бичиг байна. Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 88,86%-тай байна.

Байгууллагын архивын үйл ажиллагааны талаар



Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/15 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Байгууллагын захиргааны албан хаагчдаас 2025 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын санал авч, 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын дэргэдэх БНШК-н хурлаар хэлэлцэж, байгууллагын даргаар батлуулсан.

2025 онд байгууллагын архивт 2024 оны ХХНЖ-ын дагуу захиргаа хүний нөөцийн хэлтэс, тээвэр зохицуулалтын хэлтсээс цаасан суурьтай 85 баримтыг нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авав.

2024 оны байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 49, боловсон хүчний холбогдолтой 141, нийт 190 захирамжлалын баримтыг Нийслэлийн архивын www.arch.ulaanbaatar.mn программд шивж цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Нийслэлийн архивын газраас гаргасан хуваарийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн актаар цахим нөхөн бүрдүүлэлтийг хүлээлцсэн.

Байгууллагын архивт хадгалагдаж буй баримтыг данс бүртгэлийг Нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж данс бүртгэлээ батлуулсан.

Байнга хадгалах баримт, захирамжлалын цахим баримтыг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтэст байнга хадгалах баримт 190, захирамжлалын цахим баримт 19 (Hard) актаар хүлээлгэн өгсөн.



(Устгах жагсаалтын дагуу устгал хийж байна)


Нийслэлийн Архивын газрын БНШАЗК-ын хурлаар батлагдсан түүх эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй баримтыг устгах баримтын жагсаалтын дагуу байгууллагын баримт нягтлан шалгах комиссын хяналтан дор 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 409 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги дээр 34 хэргийн 372 баримтыг устгасан.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон Шилэн дансны тухай хуулийн хүрээнд төрийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг <http://baazweb.super-assist.com/> цахим хуудсанд, байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт, гүйцэтгэл, тайлан мэдээ, Дотоод журам болон

бусад дүрэм, журмууд даргын баталсан тушаал, тендерийн урилга, зар, санхүүгийн тайлан мэдээллийг тухай бүрт нь байршуулан ажилласан.

Мөн Шилэн ажиллагаа <https://shilen.gov.mn/home-д> 2025 оны 2 дугаар улирлын нээлттэй мэдээллийг байршуулж тайланг илгээсэн.



Байгууллагын фейсбүүк дэх цахим хуудсыг нээж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг “www.baaz.ub.gov.mn”, фейсбүүк дэх page хуудас, байгууллагын дотоодын группт нийтлэн ажиллаж байна.